

【モンゴル語】

留学生のしおり

Study Guidebook



★かならず読んでください。

Make sure to read all of this instructions.

★大切に保管してください。

Please always keep this file while you are in Japan.

学籍番号 Student No.	氏名 Name

ABK


Японд амьдрахад анхаарах зүйлс**Хуудас**

1.	Оршин суугчийн карт ба оршин суугчдын бүртгэлийн систем	2
2.	Хувийн дугаар (“Миний дугаар”)-н тогтолцоо.....	3
3.	Иргэний эрүүл мэндийн даатгал.....	4
4.	Иргэний тэтгэврийн даатгал	6
5.	Хог хаях арга.....	6
6.	Унадаг дугуй	9
7.	Арбайт буюу цагийн ажил.....	11
8.	Банкны данс	12
9.	Эзгүй үеийн мэдэгдэл хуудас	13
10.	Түр хугацаагаар нутаг буцах	13
11.	Гар утас	14
12.	Согтууруулах ундаа, тамхи	14
13.	Яаралтай тохиолдолд холбоо барих	14
14.	Хориотой эмийн зүйлийн талаар	15
15.	Ахуйн дуу чимээ.....	15
16.	Бусад.....	15

Сургуулийн дүрэм болон бусад**Хуудас**

1.	Оюутны үнэмлэх	16
2.	Ирц.....	16
3.	Тодорхойлолт гаргуулах	17
4.	Сургалт дүүргэхтэй холбогдох журам	18
5.	Сургалтын тэтгэлгийн систем	19
6.	Сургуулийн даатгал.....	19
7.	Хар салхины улмаас хүчтэй шуургатай үед эсвэл газар хөдлөлт үүссэн тохиолдолд хичээл орох нь.....	20
8.	Сургуульд явахыг хориглох халдварт өвчнүүд.....	23
9.	Бусад.....	23

登校許可書.....	25
------------	----



Японд амьдрахад анхаарах зүйлс

1. Оршин суугчийн карт ба оршин суугчдын бүртгэлийн систем

Оршин суугчийн карт

Япон улсад дунд болон урт хугацаагаар оршин суух оршин суугчдад, Япон улсад нэвтрэх зөвшөөрөл, оршин суух эрхийн төрлийг өөрчлөх зөвшөөрөл, оршин суух хугацааг шинэчлэх зөвшөөрөл зэрэг оршин суух зөвшөөрөл олгоход, эдгээрийг дагалдан оршин суугчийн карт олгогдоно. Оршин суугчийн карт нь, Японд оршин суух хугацаанд биеийн байцаалт болох тул, алдаж гээгдүүлэхээс болгоомжилно уу.

Оршин суугчийн карттай холбогдох өргөдлийг гаргах хугацаа нь тогтсон байдаг ба тогтсон хугацаанд нь багтааж өргөдөл гаргаагүй тохиолдолд, 200,000 иенийн торгууль зэрэг торгууль ноогдуулдгийг анхаарна уу.


Оршин суугчийн картыг байнга биедээ авч явах үүрэг

Оршин суугчийн картыг байнга биедээ авч явах ёстой. Цагдаагийн газрын ажилтан “Оршин суугчийн картаа үзүүлнэ үү.” гэвэл, үзүүлэх үүрэгтэй байдаг. Оршин суугчийн картыг биедээ авч яваагүй тохиолдолд, үзүүлэхийг эсэргүүцсэн тохиолдолд торгууль ноогдуулдаг.

Алдаж гээгдүүлсэн тохиолдолд

Оршин суугчийн картаа гээгдүүлсэн, хулгайд алдсан тохиолдолд,

- (1) Сургалтын албанад мэдэгдэнэ үү.
- (2) Цагдаагийн газарт “Алдсан зүйлийн мэдэгдэл” гаргаж, мэдэгдлийнхээ дугаарыг мэдэж авна уу.
- (3) 14 хоногийн дотор Гадаадын иргэдийн бүртгэлийн газарт дахин гаргуулах өргөдөл гаргана уу.



Оршин суугчдын бүртгэлийн систем

Оршин суугчдын бүртгэлд бүртгүүлэх нь, Японы иргэдийн нэгэн ижил, дунд болон урт хугацаагаар Японд оршин суух гадаадын оршин суугчдыг мөн хамаардаг систем юм. Оршин суух газар тань тодорхой болмогц, оршин суугчийн карттайгаа, 14 хоногийн дотор Хот юм уу Дүүргийн захиргаанд очиж бүртгүүлнэ үү. Оршин суугчдын бүртгэлд овог нэр, төрсөн он сар өдөр, хүйс, оршин суух хаяг зэрэг мэдээллийг бүртгэх ба, эдгээр мэдээлэл нь “Оршин суугаа газрын захиргааны бүртгэлийн бичиг” олгох гэх мэт захиргааны үйлчилгээний ажлыг гүйцэтгэхэд хэрэглэгдэнэ.

Оршин суух газраа өөрчилсөн тохиолдолд (Нүүх болсон тохиолдолд)

- (1) Нүүх болсон тохиолдолд, “Шилжин гарах мэдэгдэл”-ийг оршин суугаа дүүрэг /хотын захиргаанд очиж хураалган, “Шилжин гарсан тодорхойлолт” гаргуулж авна уу.
- (2) Нүүснийхээ дараа, 14 хоногийн дотор шинээр оршин суух газрынхаа дүүрэг /хотын захиргаанд очиж, “Шилжин орох мэдэгдэл”-ийг бичиж өгнө үү.
 - * Шилжин гарах болон шилжин орох мэдэгдлийг гаргахдаа, оршин суугчийн картаа заавал авч явна уу.
 - * Гадаад руу нүүх тохиолдолд (Нутаг буцах үед) ч, заавал “Шилжин гарах мэдэгдэл”-ийг хураалгана уу.
 - * Оршин суугчийн картны хаяг болон бодит хаяг нь хоорондоо тохирохгүй тохиолдолд, тортгуйль ноогдуулдаг.

Оршин суугчийн карт болон Эрүүл мэндийн даатгалын картыг зээлж, зээлдүүлэхийг хуулиар хориглосон байдал ба, зээлдүүлсэн хүн, зээлсэн хүний аль алинд нь тортгуйль ноогдуулдаг. Найз нөхөд, таньдаг хүн байлаа ч зээлдүүлж, зээлж хэрхэвч болохгүй.

Харьяалагддаг байгууллага өөрчлөгдсөн тохиолдолд

Сургуулиас гарах үед болон сургуулиа төгссөн үед Цагаачлалын албан (дүүргийн газар биш) харьяалагддаг байгууллага өөрчлөгдсөн гэдгээ мэдэгдэх үүрэгтэй.

Бичих цаас өгөх учир оффисд ирээрэй.

2. Хувийн дугаар (“Миний дугаар”) -н тогтолцоо


Хувийн дугаарын систем

Оршин суух хаягийн зөвшөөрлийн картыг эзэмшидэг гадаад оюутнуудад Хувийн дугаар нь хүн тус бүрчлэн олгогдоно.

Хувийн дугаарын мэдэгдэх хуудас

Мэдэгдэх хуудас нь Хувийн дугаарын талаар мэдээлэл өгөх зорилготойгоор олгогддог. Японд ирээд иргэний бүртгэл хийлгэсний дараа мэдэгдэх хуудас хотын захиргааны газраас хүргэгдэнэ. Хувийн дугаар нь Японд паспорт болон оршин суух үнэмлэхтэй дүйцэхүйц хэмжээний чухал бичиг баримтанд тооцогддог тул хаяж үрэгдүүлэхгүй байхад онцгой анхаарна уу.

Мэдэгдэх хуудсаа авсны дараа хаяж үрэгдүүлэхгүй байхад анхаарна уу.



Ямар үед хувийн дугаарыг ашиглах вэ?

Хуулийн хүрээнд болж буй бүхий л үйл ажиллагаа, бичиг баримт бүрдүүлэлт болон ажилд орох гэсэн нөхцөлүүдэд хотын захиргааны газарт Хувийн дугаарыг ашиглах шаардлагатай болно. Хувийн дугаар нь хувийн мэдээлэл бүгдийг нь илтгэж байдаг тул үл таних хүмүүст болон хэрэгцээ үүсээгүй нөхцөлд зааж өгөх, хуваалцахаас зайлсхийх хэрэгтэй. Хэн нэгэнд хувийн дугаараа зааж өгөхдөө анхааралтай байна уу.

Хувийн дугаарын карт

Энэхүү карт нь таны хувийн дугаар болон ID зургийг агуулж байдаг. Энэхүү карт нь таныг илтгэх үнэмлэх болох учир олон төрлийн үйл ажиллагааны үед ашиглагдана. Хувийн дугаарыг авах хүсэлтийн форм нь мэдэгдэх хуудасны хамт шууданд тань хүргэгдэх болно.

Өгөгдсөн зааврийн дагуу формийг бөглөж Хувийн дугаарын картыг авах хүсэлтийг илгээнэ. Гэхдээ, энэхүү картыг заавал авах албагүй бөгөөд хэрэгцээгүй үед авах хүсэлт гаргахгүй байсан ч болно.



3. Иргэний эрүүл мэндийн даатгал


Иргэний эрүүл мэндийн даатгалд бүх иргэд хамрагддаг системтэй

Оршин суугчдын бүртгэлд бүртгүүлсний дараа, мөн дүүрэг /хотын захиргааныхаа Иргэний эрүүл мэндийн даатгалын хэлтэс дээр очин, “Иргэний эрүүл мэндийн даатгал”-д хамрагдах хэрэгтэй. Япон нь “Иргэн бүр даатгалд хамрагддаг систем”-тэй бөгөөд, энэ нь даатгуулагчдын орлогын хэмжээнд нь дүйшүүлэн даатгалын шимтгэлийн хэмжээг тогтоодог эв санааны нэгдлийн зарчимд тулгуурласан систем юм.

Анхааруулга: Японд оршин суух гэр бүлийн хүн тань нийгмийн даатгалд хамрагдсан тохиолдолд, Сургалтын албанад хандаж, тэр талаар тодруулна уу.

Эрүүл мэндийн даатгал нь өвчин туссан тохиолдолд баталгаа болно

Эрүүл мэндийн даатгалд хамрагдахгүй бол, мухар олгойн үрэвсэл гэх мэтийн харьцангуй хөнгөн өвчинөөр 1 долоо хоног орчим эмнэлэгт хэвтэн, мэс засал хийлгэлээ гэхэд, хэдэн зуун мянган иений зардал шаардагдана. Гадаадын оюутны хувьд, эмнэлэгт хэвтэх, эмчилгээ хийлгэх зардлыг төлнө гэдэг нь, сурч амьдрах үндэс суурийг нь үндсээр нь тогтвортгүй болгох шалтгаан болох болов уу. Иймээс, эрүүл мэндийн даатгалын систем нь, өвчин туссан тохиолдолд, эдийн засгийн ачааллыг байж болох хамгийн бага хэмжээнд барих зорилготой баталгааны системийн үүргийг ч гүйцэтгэдэг.



Даатгалд хамрагдах арга

Бүртгүүлэх газар: Оршин суугаа газрын дүүрэг /хотын захиргааны Иргэний эрүүл мэндийн даатгалын хэлтэс


Шаардагдах бичиг баримт: (1) Оршин суугчийн карт (2) Паспорт

Даатгалын шимтгэлийн хөнгөлөлт

Өнгөрсөн жил орлогогүй байсан хүн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт эдлэх боломжтой. Даатгалд хамрагдах үедээ ажилтанд нь тэр талаар мэдэгдэнэ үү. Мөн дараагийн жилээс нь эхлэн, өмнөх жилийн орлогын хэмжээнээс шалтгаалан даатгалын шимтгэл нь харилцан адилгүй байна. Мөн орлогогүй байсан тохиолдолд, дүүрэг /хотын захиргааныхаа Татварын албаны хэлтэст орлогогүй байсан талаараа жил бүр мэдэгдэл гаргах шаардлагатай.

Даатгалын шимтгэл

Даатгалын шимтгэлийн нэхэмжлэх хуудас нь жилд 1 удаа (Бүнкио дүүргийнх 7 дугаар сарын дундуур) шуудангаар хүргэгдэнэ. Заасан хугацаанд нь багтаан, банк, шуудан, конбини буюу 24 цагийн дэлгүүр, эсвэл дүүрэг /хотын захиргаан дээр очиж төлнө. Даатгалын шимтгэл нь бус нутаг бүр харилцан адилгүй байх ба, хөнгөлөлт эдлэх боломжтой тохиолдолд, 1 жилийн шимтгэл нь 12,000 орчим иен байдаг. Даатгалын шимтгэлээ төлөхгүй бол, шинээр даатгалын карт олгогдохгүй байх, хүчинтэй хугацаа нь бодиносох зэрэг асуудал гардаг. Мөн, “Оршин суух эрхийн төрлийг өөрчлөх өргөдөл”, “Оршин суух хугацааг шинэчлэх өргөдөл” гаргахад даатгалын картаа үзүүлэх шаардлагатай байдаг.



Нүүсэн тохиолдолд

- (1) Нүүхээсээ өмнө оршин сууж байсан дүүрэг /хотын захиргаанд “Шилжин гарах мэдэгдэл” хураалгахдаа, даатгалын хуучин картаа буцааж өгнө үү.
- (2) Нүүж очсон дүүрэг /хотын захиргаанд “Шилжин орох мэдэгдэл” хураалгахдаа, даатгалын шинэ карт гаргуулж авна уу.

Даатгалыг хэрхэн ашиглах

Өвчин тусч, эмнэлэгт үзүүлэх тохиолдолд, эмчилгээний байгууллагын хүлээн авахад нь Иргэний эрүүл мэндийн даатгалын картаа заавал үзүүлнэ үү. Эмчилгээний зардлын 70% нь Иргэний эрүүл мэндийн даатгалаас төлөгдөх ба 30%-ийг нь өөрөө төлнө.

Иргэний эрүүл мэндийн даатгалын карт гаргуулсан, өөрчилж шинэчилсэн, даатгалын шинэ карттай болсон тохиолдолд, Сургалтын албанд заавал авчирч үзүүлнэ үү.

Нутаг буцах тохиолдолд

Нутаг буцах тохиолдолд, Иргэний эрүүл мэндийн даатгалаас гарах хүсэлт гарган, даатгалын шимтгэлийн эцсийн тооцоог хийх хэрэгтэй. Түр хугацаагаар нутаг буцах тохиолдолд, эдгээр зүйлсийг хийх шаардлагагүй.


Процедур(горим) нь оршин суух хот дүүргээс шалтгаалан харилцан адилгүй байдаг тул, хот дүүргийн Иргэний эрүүл мэндийн даатгалын хэлтсээс лавлаж тодруулна уу.

4. Иргэний тэтгэврийн даатгал

Иргэний тэтгэврийн даатгалын систем нь, өндөр насанд хүрэхэд болон гэнэтийн осолоор тахир дутуу болсон тохиолдолд, тухайн хувь хүний амьдралын тогтвортой байдлыг алдагдахгүй байлгахын тулд, нийгэм нийтээрээ харилцан туслах систем юм. 20н нас хүрэх хүмүүст хот /дүүргийн захиргаанаас Иргэний мэдэгдэл захидал 「基礎年金番号通知書」 шуудангаар хүргэгдэх ба, мэдэгдэл захидал 「基礎年金番号通知書」 нандигнан хадгална уу.

Оюутнууд даатгалын шимтгэлээс чөлөөлөгдөх, эсвэл хөнгөлөлт өдлэх хүсэлт гаргах боломжтой тохиолдол байдаг. Шимтгэлээс чөлөөлөгдөх, хөнгөлөлт өдлэх хүсэлт гаргах арга нь өөр өөр байдаг тул, Иргэний тэтгэврийн мэдэгдэл болон мэдэгдэл захидал 「基礎年金番号通知書」 хүлээж авбал, тэр даруйд нь Сургалтын албанад мэдэгдэнэ үү.

▼基礎年金番号通知書（мэдэгдэл захидал）



5. Хог хаях арга

Гадаадаас ирсэн хүмүүс болон ойр орчны оршин суугчдын хооронд гардаг хамгийн түгээмэл асуудалд хог хаях аргатай холбогдох асуудал байдаг. “Хогийг яаж ч хаясан ялгаа байхгүй.” гэж бодож байгаа хүн байхгүй биз? Токио хотод айл өрхөөс гарах хогийг, бүгдийг нь тогтсон аргаар ангилан, тогтсон өдөр цагт нь, тогтсон газарт нь аваачиж тавихгүй бол, хогны машин цуглувж өгөхгүй. Энэ аргыг дагаж мөрдөх нь хотод амьдрах эхний алхам болно.

5-1. Сургуулийн дотоод хэсэгт хог ангилах нь

АВК-д хогийг дараах байдлаар ангилана. Сургууль доторх гарах хогийг зөв ялан хогийн саванд нь хаяж байх. Мөн анги болон ариун цэврийн өрөөнд хог үлдээхгүй байхыг анхаарна уу.

(1) Шатдаг хог → цаасан хог хаягдал (цаасан хаягдал, винилэн гадаргуутай цаас, салфетка, хоолны үлдэгдэл, нэг удаагийн савх, шүдний цаас, цаасан сав, цаасан таваг/цаасан аяга, цайны шаар, дурдэг цай, гэрэл зураг)

かみ紙 	ビニールコート紙 	かみざら 紙皿・紙コップ・紙容器 プラスチック・発泡スチロール容器 はプラスチックごみ
わりはし・つまようじ 	ざんばん 残飯 	ちゃがら 茶殻・ティーバッグ

(2) Хуванцар хог → хоолны сав · тавиур, гялгар уут, гоймонгийн сав, чихрийн уут, хуванцар савны шошго болон таглаа, хуванцар бичгийн хэрэглэл, соруул, аяга угаах спонж, полимер, хуванцар сав. [Анхааруулга] Хоолны үлдэгдлийг шатдаг хог хаягдал, дэлгүүрийн хоолны савыг хуванцар хог хаягдал руу тус тус ялган хаяна уу.

弁当箱・トレイ 	ビニール袋 	カップ麺容器 	菓子袋 
ペットボトルラベル 	キャップ・ふた 	プラスチック製文具 	使い捨てスプーン 
ストロー 	ウレタン・スポンジ 	発泡スチロール 	プラスチック・ビニール製容器 

(3) Шатдаггүй хог → резин, металл, шил, шаазан, арьсан эдлэл, хөнгөн цагаан тугалган цаас, CD · DVD

ゴム 	金属類 	ガラス 	陶磁器 
皮革製品 	アルミホイル 	CD、DVD 	

- (4) “Pet bottle” → доторх шингэнг ургсан хоослоно. Гаднах шогшо болон таглааг хуванцар хог руу хаяна.
(5) Лааз → доторх шингэнг ургсан хоослоно.
(6) Шил → доторх шингэнг ургсан хоослоно. Металлан тагийг шатдаггүй хог руу хаяна.

ビン



カン



ペットボトル



キャップ・ラベルはプラスチックごみ

5-2. Гэр ахуйн хог хаягдлыг ангилах нь

Гэр ахуйн хог ангилах арга нь бүс нутаг бүр өөр хоорондоо харилцан адилгүй байдаг. Бүнкёо дүүрэгт дараах байдлаар ангилана. Үүнд:

- (1) Шатдаг хог → Шатаахад тохиромжтой хог (Түүхий хог, цаас, хувцас, хуванцар зүйл, хулдаас, резин г.м) Токио хотод, хагас тунгалаг юм уу тунгалаг гялгар уутанд хийж, амыг нь баглаж хаядаг.



- (2) Шатдаггүй хог → Шатаахад тохиромжгүй хог (Шилэн эдлэл, шаазан эдлэл, гэрлийн чийдэн г.м). Аюулгүй зүйл бол, доторх зүйл нь гаднаасаа танигдахуйц тунгалаг уутанд хийж хаяна уу.



- (3) Овортой хог → Том хог (Гэрийн тавилга, унадаг дугуй г.м)-ийг хаяхад, Цэвэрлэгээний газар руу утсаар ярьж, мэдэгдэнэ үү. Овортой хогийг хаяхад жич төлбөртэй байдаг.



- (4) Нөөц баялаг болох хог → Дахин боловсруулах боломжтой хог (Хуучин сонин, шил, лааз г.м) Хуучин сониныг олсоор баглан, шил, лаазыг тогтсон саванд нь хийнэ үү.



Хог гаргаж тавих арга

Хог гаргаж тавих гариг, цаг, тавих газар нь бүс нутаг бүр харилцан адилгүй байна. Бүс нутгийнхаа хог цуглуулах цэгийн самбараас харах, эсвэл хөрш айлынхаа хүмүүсээс асууна уу.

☆Анхааруулга

Японд “Гэр ахуйн электрон барааг дахин боловсруулах тухай хууль” гэж байдаг ба уг хууль нь агааржуулагч, телевизор, хөргөгч, угаалгын машин зэрэг гэр ахуйн электрон барааг хаяхад, худалдаж авсан дэлгүүр нь цуглуулж авна гэсэн агуулгатай. Худалдаж авсан дэлгүүрийнхээ нэрийг мартсан, эсвэл мэдэхгүй тохиолдолд, тухайн бүс нутгийнхаа Цэвэрлэгээний газартай холбоо барьж, хаях электрон бараагаа даатгана. Зардал нь 1 телевизорт 2,800 иен + тээвэрлэлтийн зардал болно.

Онцын шаардлагагүй л бол, найз нөхдөөсөө гэр ахуйн хуучин электрон бараа авахгүй байхыг зөвлөж байна. Мөн, хаяхаар гаргаж тавьсан гэр ахуйн электрон барааг ажиллагаатай гэж бодон авч харихаас татгалзана уу. (Хаяхаар гаргаж тавьсан зүйл байсан ч “Гэр ахуйн электрон барааг дахин боловсруулах тухай хууль” үйлчилнэ. Хог цуглуулах цэгээс дураараа юм авбал, завшсан хэрэгт орж, торгууль ноогдуулах тохиолдол байдаг.)

6. Унадаг дугуй

АВК-н унадаг дугуйн зогсоол дээр унадаг дугуйгаа тавих хүсэлтэй тохиолдолд, сургалтын албанд эхэлж бүртгүүлнэ үү. АВК-н дугуйны зогсоолын тоо хязгаарлагдмал тул ашиглах сонирхолтой хүн олон тохиолдолд сугалаагаар сонгоно. Сугалаанд унасан тохиолдолд зөвшөөрөлгүй газар тавихыг хориглох бөгөөд дүүргийн төлбөртэй зогсоол зэрэг хууль ёсны зогсоолд дугуйгаа тавина уу.

Орхигдсон дугуйг авч явж болохгүй

Метроны буудлын гадаа, замын хажууд хангалттай унаж болохоор дугуй хэдэн өдөр дараалан орхигдсон байх үзэгдэл их байдаг. Гэхдээ ийм дугуйг авч унаж болохгүй. Японд дугуйг хулгайгаас сэргийлэхийн тулд бүртгэдэг систем байдаг. Цагдаагийн газрын шалгалтаар, олсон дугуй болох нь тодорхойлогдвол “Дугуйны хулгайч” болчихно.

Дугуй худалдаж авбал

Дугуй худалдаж авбал, худалдаж авсан дэлгүүртээ хулгайгаас сэргийлэх бүртгэл хийлгэнэ.

Дугуй хүнээс авбал

Найз нөхдөөсөө дугуй авах тохиолдолд, хулгайгаас сэргийлэх бүртгэл хийгдсэн эсэхийг нь магадлан, эрх шилжүүлэх бичиг болон хулгайгаас сэргийлэх бүртгэлийн хуулбарыг нь марталгүй авна уу.

Эрх шилжүүлэх бичигний загвар →

Би _____ -д дугуйныхаа эрхийг шилжүүлэв.	Эрх шилжүүлэх бичиг 20__ оны __-р сарын __
Бүртгэлийн дугаар: _____	Хаяг: _____
Эрхийг хүлээн авагчийн овог нэр: _____	Хаяг: _____

Дугуйны осол нэмэгдэж байна

АВК-д ч дугуйны осол ихээр нэмэгдэж байна.

Зам тээврийн осол нь хохирогч нь болсон ч, хохирол учруулагч нь болсон ч, оюутны амьдралд сайн нөлөө үзүүлэхгүй. Токио шиг хотод дугуй унахын аюулыг сайтар ойлгож ухамсарласны үндсэн дээр унана уу.

Дугуйг хоёроороо унах, шөнө орой гэрлээ асаалгүй унах, зонтик барингаа унах, гар утсаараа ярингаа унах нь замын хөдөлгөөний дүрмийг зөрчсөнд тооцогдоно. Замын хөдөлгөөний дүрмийг зөрчсөн тохиолдолд, хохирогч байсан ч зөрчлийн хариуцлагыг хүлээх болно.

Дугуйны дүрмийн жишээ

じてんしゃやあんぜんりょうごそく 自転車安全利用五則



1. **じてんしゃは、車道が原則、歩道は例外**
2. **車道は左側を通行**
3. **歩道は歩行者優先で、車道寄りを徐行**
4. **安全ルールを守る**
 - ◆ 飲酒運転・二人乗り・並進の禁止
 - ◆ 夜間はライトを点灯
 - ◆ 交差点での信号遵守と一時停止・安全確認
5. **子どもはヘルメットを着用**

じてんしゃ 自転車ルールの改正

道路交通法の改正（2008年6月1日施行）により、
自転車利用のルールは次の通りです。



1. **自転車が歩道を通行できる場合は—**
 - ◆ 「歩道通行可」の標識等があるとき
 - ◆ うんてんしゃが13歳未満の子ども・70歳以上の高齢者・身体の不自由な方
 - ◆ 道路工事など、車道や交通の状況から自転車走行に適さないとき
2. **13歳未満の子どもが自転車に乗車する場合、保護者は、ヘルメットを着用させるよう努めなければなりません。**

Гар утсаа оролдонгоо дугуй унах болон зонтик барингаа дугуй унах нь маш аюултай үйлдэл учраас, ийм үйлдэл хийхээс татгалзана уу.



[Торгууль] 50,000 иен хүртэлх мөнгөн торгууль

7. Арбайт буюу цагийн ажил



Цагийн ажил хийхэд зөвшөөрөл хэрэгтэй

“Оюутны”, “Гэр бүлийн” виза нь, үндсэндээ ажил хийхийг хориглодог төрлийн оршин суух эрх юм. Тиймээс, цагийн ажил хийхийн тулд, Гадаадын иргэдийн бүртгэлийн газраас “Оршин суугчийн статусаас өөр үйл ажиллагаа хийх зөвшөөрөл”-ийг авах шаардлагатай. Японд ирэх үедээ нисэх онгоцны буудал дээрээс “Оршин суугчийн статусаас өөр үйл ажиллагаа хийх зөвшөөрөл” аваагүй оюутнууд, дараа нь “Оршин суугчийн статусаас өөр үйл ажиллагаа хийх зөвшөөрөл” авахыг хүссэн тохиолдолд, Гадаадын иргэдийн бүртгэлийн газарт өргөдөл гаргана уу.

Өргөдөл гаргах арга

Өргөдөл гаргах газар: Гадаадын иргэдийн бүртгэлийн газар

Шаардагдах бичиг баримт:

- (1)“Оршин суугчийн статусаас өөр үйл ажиллагаа хийх зөвшөөрөл” авахыг хүссэн өргөдөл
- (2)Паспорт (3)Оршин суугчийн карт (4)Оюутны үнэмлэх



Гадаадын иргэдийн бүртгэлийн газарт очиж, оршин суугчийн картныхаа ард талд “Оршин суугчийн статусаас өөр үйл ажиллагаа хийх зөвшөөрөл”-ийн тамга даруулж, паспортондоо “Оршин суугчийн статусаас өөр үйл ажиллагаа хийх зөвшөөрөл”-ийн наалт наалган, Сургалтын албанд оршин суугчийн карт болон паспортоо авч ирнэ үү. Тамга, наалтны хуулбарыг авна.

Цагийн ажлын талаарх мэдэгдэх хуудас

<https://forms.gle/JHkcG1dbxpFJbUpJ6> (\leftarrow GoogleForm \rightarrow)



Цагийн ажил хийж эхэлсэн бол заавал оффис дээр ирж “Цагийн ажлын мэдэгдэл”-г бичиж хураалгаарай. Ажлын цагийн менежментийн улмаас нэгээс олон цагийн ажил хийхийг зөвлөхгүй ч, олон газарт ажиллах бол бүх ажиллаж буй газраа “Цагийн ажлын мэдэгдэл”-д бичиж оффис дээр хураалгана уу. Хэрэв цагийн ажлаа сольж байгаа бол оффис дээр ирж шинэ мэдэгдэл бичнэ үү.

★Хэрэв та хоёр газарт ажилладаг бол нийт ажиллах цаг 28 цагаас хэтрэхгүй байх ёстойг анхаарна уу! ! !

アルバイト希望書	
（学生・クラブの先生・監修 ABK COLLEGE事務局）	
アルバイト先が決まったら、この報告書を必ずABK COLLEGE事務局に提出してください。	
学年・学年番号：	クラス_____ 年 班
氏名：	ニックネーム：
勤務先名：	
勤務先電話番号：	
勤務先住所：	
業種：ロール 口キッチン ロレジ、税理 口製造 口その他（ ）	
勤務日時：口日曜 口月曜 口火曜 口水曜 口木曜 口金曜 口土曜 ロフト制／不定期（1週間に一回くらい） 口その他の（ ）	
勤務時間数：1週間に中で_____ 時間	勤 総：_____ 時間
勤入日：_____ 年 _____ 月 _____ 日	

Цагийн ажил хийх цаг

“Оюутан”-ы оршин суугчийн статустай хүнд зөвшөөрөгдөх оршин суугчийн статусаас өөр үйл ажиллагаа (Цагийн ажил) нь, **1 долоо хоногт 28 цагаас илүүгүй** (“Оюутан”-ы визатай тохиолдолд, зун, өвөл, хаврын амралтуудын үеэр 1 өдөрт 8 цагаас илүүгүй) байна.

“Гэр бүлийн оршин суух виз”-тэй бол цагийн ажил хийж болох хэмжээ,

1 долоо хоногт 28 цагаас илүүгүй байна.

※Зун, өвөл, хаврын амралтаар ч долоо хоногт 28 цаг байна. 1 өдөрт 8 цаг биш.

★Шөнийн цагаар ажиллахыг [22:00-5:00цаг] АВК-д хориглоно. Учир нь энэ нь таны хичээлийн анхаарал төвлөрөлт, хичээлийн идэвхид сергэөр нөлөөлнө.

Цагийн ажил хийх салбар

★Тогтсон цагаас илүү гараахгүй байлаа ч, зугаа цэнгээний төрлийн салбарт ажиллахыг хатуу хориглодог. Ийм төрлийн газарт (шөнийн клуб г.м) таваг угаах, цэвэрлэгээ хийх зэрэг ажил байсан ч ажиллахыг хориглодог.

★Uber-Eats болон Demaessen гэх мэт хоол хүргэлтийн үйлчилгээний ажилд ажиллахыг хуулийн дагуу гадаад оюутнуудад хориглоно.

★“Нэг өдөрт 30000 иэний цалинтай”, “Бага цаг ажиллаад их цалин авна” гэсэн ажил байхгүй. Токиод цагийн ажлын дундаж цалин 1100-1200иэн хавьцаа байдаг. Ажил хийж эхлэх үедээ тухайн ажиллах газрасаа “Ажлын гэрээ”-г заавал аваарай.



Тогтсон цагаас хэтэрч ажилласан, хориглодог ажлыг хийсэн тохиолдолд...

Тогтсон цагаас хэтэрч ажилласан, хориглодог ажлыг хийсэн тохиолдолд, “Оршин суугчийн статусаас өөр үйл ажиллагаа хийх зөвшөөрөл”-тэй байсан ч хууль зөрчсөнд тооцогдох ба, зарим тохиолдолд, Гадаадын иргэдийн бүртгэлийн газарт хоригдох, албадан нутаг буцаах явдал байна.

Гадаад хүн ажиллуулж байгаа албан байгууллагын хувьд дүүргийн газарт ажилласан цагийн бүртгэлийг тогтмол мэдэгдэж байдаг тул цагаачлалын алба ч мөн мэдэж байдаг. Тиймээс ажиллах цагийн хязгаарыг заавал баримтална уу.

8. Банкны данс

Банкны данс нээлгэхэд тамга болон хаягийн бүртгэл хийлгэсэн оршин суух үнэмлэх шаардлагатай.

Бүртгэлтэй оршин суух үнэмлэх нээлгэхийн тулд харьяа дүүрэгтээ бүртгэл хийлгэх шаардлагатай учраас нэн даруй бүртгэлээ хийлгэнэ үү.

『Юучо』 банкинд данс нээлгэхдээ гэрийнхээ ойролцоох банкинд өөрийн биеэр очиж дансаа нээлгэнэ үү.

★Япон банк буюу “Юучо” банкны гадаад улстай хийх гүйлгээний талаар

Гадаад улсаас Юучо банкны дансуу гүйлгээ хийх тохиолдолд АНУ-н доллараар хийх боломжтой.

Дэлгэрэнгүй мэдээллийг доорх веб хуудаснаас тодруулна уу.

<Юучо банкны веб хуудас>

Япон хэл : http://www.jp-bank.japanpost.jp/kojin/sokin/kokusou/kj_sk_ks_gaikoku.html

Англи хэл : http://www.jp-bank.japanpost.jp/en/djp/en_djp_index.html

★Тамганы талаар

Японд банкны үйлчилгээ авах, шуудан хүлээж авах болон түүнээс гадна өдөр тутмын амьдралд, Их сургуулийн шалгалт өгөхөд ч тамга шаардлагатай болдог. Тамга нь Японд амьдрах хугацаанд байнга хэрэглэгдэх зүйл тул, нандигнан хадгална уу. Тамгыг мод, чулуу, хуванцар зэрэг материалаар хийлгэнэ үү. Дарах хэсэг нь резин бол хэрэглэх боломжгүй анхаарна уу.


9. Эзгүй үеийн мэдэгдэл хуудас

Эзгүй үеэр баталгаатай шуудан, EMS, ачаа зэрэг зүйлс ирсэн тохиолдолд, шуудангийн ажилтан, тээврийн компанийн ажилтан нь “Эзгүй үеийн мэдэгдэл хуудас” (Шууданг түр хадгалж буй талаар мэдэгдэх мэдэгдэл) шуудангийн хайрцганд үлдээдэг. Дараах зургандаа үзүүлсэн шиг Гэртээ байгаагүй улмаас шууданг хүргэж өгч чадаагүй гэсэн бичиг шууданд чинь байвал QR Codey-г нь уншуулж интернетээр бүртгүүлэн гэртээ шуудангаа дахин хүргүүлж авчгаая.

Тодорхой хугацааны дотор хүсэлт гаргахгүй тохиолдолд, явуулсан эзэнд нь буцааж хүргэгдэх юм уу устгагдах болдог тул анхаарна уу. Хүсэлт хэрхэн гаргахаа мэдэхгүй тохиолдолд, Сургалтын албанад Эзгүй үеийн мэдэгдэл хуудсаа авч ирнэ үү. Хүсэлтийг орлон гаргана.

[Шуудангийн Эзгүй үеийн мэдэгдэл хуудас]

[Ямато тээврийн Эзгүй үеийн мэдэгдэл хуудас]



10. Түр хугацаагаар нутаг буцах

Түр хугацаагаар Японоос гарах тохиолдолд

Сурч байх хугацаандаа, амралтаа ашиглан түр нутаг буцах тохиолдолд, Японоос гарах үед хүчинтэй паспорт болон оршин суугчийн карттай байж, Японоос гарснаас хойш 1 жилийн дотор, эсвэл Японы визаны хүчинтэй хугацааны аль нэгнийх нь эрт дуусах өдрөөс нааш дахин Японд эргэж ирэх тохиолдолд, “Дахин нэвтрэх зөвшөөрөл олгогдсонд тооцох” журам үйлчлэх учраас, “Дахин нэвтрэх зөвшөөрөл”-ийг авах шаардлагагүй.

Японоос гарахдаа, оршин суугчийн картаа заавал үзүүлнэ үү.

Заагдсан хугацааны дотор Японд заавал эргэж ирэх хэрэгтэй

“Дахин нэвтрэх зөвшөөрөл олгогдсонд тооцох” журам нь 1 жилийн дотор, эсвэл зөвшөөрөл олгогдсон тухайн үеийн оршин суух хүчинтэй хугацааны дотор эргэж ирэхгүй бол хүчингүй болох тул, анхаарна уу.

Мөн, онцгой шалтгаантай тохиолдлыг үл тооцон, хичээлээс чөлөө авч түр нутаг буцахыг зөвшөөрөхгүй.

Онцгой шалтгаантай тохиолдолд, багшаасаа зөвшөөрөл авсны дараа сургуулийн тогтсон маягтанд эцэг эх зэрэг холбогдох хүнээр шалтгаан бичиг бичүүлж хураалгана уу. (Дэлгэрэнгүй мэдээллийг “2. Ирц”-ийн “(1) Албан ёсны чөлөө”-нөөс харна уу.)

外国人用 (再入国) 480875	氏名 (漢字) Family Name Given Names	姓 Name	姓 Name	男 男 Male	女 女 Female
国籍-地域 生年月日 性別 性別 性別	國籍-地域 姓 Name	性別 性別 性別	性別 性別 性別	性別 性別 性別	性別 性別 性別
以下の署名について、該当するものに☑を記入し、署名（特別な住處の方は 署名として下さい。）して下さい。Special residence place, please put your signature only. 1.あなたは、日本国外又は日本国外の船において、刑罰事件で差押件決 を受けることがありますか？ Have you ever been found guilty in a criminal case abroad? Yes <input checked="" type="checkbox"/> No <input type="checkbox"/> 2.あなたは、刀剣、鎧兜、大鎗、兜へん（兜に付せり）等の用兵装備又 は銃砲、刀剣若しくは火薬類等を所持していませんか？ Do you presently have in your possession narcotics, marijuana, opium, stimulants, or other drugs, swords, armors, helmets or other such items? Yes <input type="checkbox"/> No <input checked="" type="checkbox"/> No 3.あなたは、現在、現金をもつておられますか？ How much money in cash do you presently have in possession? (例: 1,000 元)					
1.再入国情件による出港を希望します。Departure with Re-entry Permission. □ 2.みなし再入国情件による出港を希望します。Departure with Special Re-entry Permission.					
3.機内持出料金の範囲内に運送料金を支払つけてあります。Please pay the air freight charges within the range of the carriage fee. □ 4.機内持出料金の範囲外に運送料金を支払つけてあります。Please pay the air freight charges beyond the range of the carriage fee.					
署名 Signature Office Use Only					

11. Гар утас

Японд амьдрахад гар утас худалдаж авах хүн олон байдаг. Харин, мэдэгдэхүйц их хэрэглээгүй мэт санагдах хэрнээ, гар утасны компаниас маш өндөр хэмжээний төлбөр нэхэмжлэгдэх тохиолдол гардаг. Утасны төлбөр өндөр гарах шалтгаанд улс хоорондын яриа, интернетийн хэрэглээ, дууны файл зэрэг файл татаж авах, тоглоом зэрэг апликешийн ашиглалт гэх мэт орох ба, эдгээрийг ашигласан тохиолдолд сүлжээний төлбөр маш өндөр болдог. Мөн, зарим төрлийн утаснууд автоматаар сүлжээнд холбогддог. “Мэдээллийн төлбөр үнэгүй” байсан ч “Сүлжээний төлбөр” нь тусдаа гардаг учраас, ашиглах тохиолдолд гэрээний агуулга болон төлбөрийн төрлүүдтэй нь маш анхааралтай танилцах хэрэгтэй.

Мөн, гар утсаа бусдад өгөх, гэрээ хийхэд нэрээ хэрэглүүлэх зэрэг үйлдлийн улмаас гэмт хэрэгт хутгалдах тохиолдол ч гардаг тул, эдгээр үйлдлийг хэрхэвч хийж болохгүй. Нутаг буцахдаа (Түр хугацаагаар нутаг буцахыг үл тооцон) гэрээгээ марталгүй цуцална уу.

12. Согтууруулах ундаа, тамхи

Японд 20-иос дээш насны хүмүүст согтууруулах ундаа, тамхи хэрэглэхийг зөвшөөрдөг. Насанд хүрээгүй хүн (20 нас хүрээгүй) согтууруулах ундаа уух, тамхи татахыг хуулиар хориглосон байдаг. Согтууруулах ундаа уух, тамхи татах нь зөвшөөрөгдсөн байлаа ч зохистой хэмжээнд барьж, бусдад төвөг удахгүй байхыг хичээнэ үү. Мөн, тамхи татаж болох газар нь тогтсон байдаг тул, тамхийг зөвхөн тогтсон газарт нь татна уу.

Түүнчлэн, тамхины ишээ таарсан газраа шууд хаялгүй, тамхины иш хаях зориулалтын саванд нь хаях зэргээр соёлыг баримтална уу.

13. Яаралтай тохиолдолд холбоо барих

Яаралтай тохиолдолд, юуны өмнө сургуулийн Сургалтын алба, эсвэл Asia Bunka Kaikan-ы хүлээн авах руу холбоо барина уу!

Аливаа хэрэг, осол, гэнэтийн өвчин зэрэг тохиолдолд, даруй Сургалтын алба, эсвэл Asia Bunka Kaikan-ы хүлээн авах руу холбоо барина уу.

ABK Япон хэлний курсын Сургалтын алба	03-3946-2171	(9:00-17:00)	*Бямба, Ням болон баяр ёслолын өдрөөс бусад
ABK COLLEGE	03-6912-0756	(9:00-17:00)	*Бямба, Ням болон баяр ёслолын өдрөөс бусад
Asia Bunka Kaikan-ы хүлээн авах	①03-3946-4121 ②090-8729-9354	(ажлын өдөр 9:00-19:00/Бямба гариг 9:00-17:00) (Дээрх цагуудаас бусад, яаралтай үе)	

Түргэн тусlamж, Гал команд [Дуудлага өгөх дугаар: **119**]

Цагдаа [Дуудлага өгөх дугаар: **110**]



14. Хориотой эмийн зүйлийн талаар

Та бүхэн эмийн зүйлийг замбараагүй хэрэглэх нь хууль бус гэдгийг, мөн аюултай чанарыг нь хангалттай сайн мэднэ гэдэгт эргэлзэхгүй байгаа боловч, үүний аюулын талаар дахин анхааруулъя. Хориотой эмийн зүйл гэгдэх зүйлд, мансууруулах бодис, хар тамхи, хууль бус болон аюултай эм зэрэг хамаарна. Сүүлийн үед, эдгээр эмийн зүйлийг харьцангуй хялбар аргаар гартаа оруулах боломж нөхцөл нь бүрдээд байгаа ба, замбараагүй хэрэглэгчдийн нас нь ч залуужиж байна. Нялуун угэнд татагдаж, хууртгдахгүй байж, сонирхох байдлаар хэрэглэж үзэх явдал гаргаж болохгүй. Хориотой эмийн зүйлийг биедээ авч явахад л хатуу торгууль ноогдуулдаг. Хориотой эмийн зүйл нь та бүхний Японд сурах зорилгыг тэр чигээр нь нураах зүйл болно. Ямар ч тохиолдолд гар сунгахгүй байх хэрэгтэй.

15. Ахуйн дуу чимээ

Оюутны байр болон орон сууцны байранд өрөөн доторх дуу чимээ нь дээд, доод давхрын өрөөнд сонсогох тохиолдол байдаг. Бага зэргийн ахуйн дуу чимээг бол харилцан тэсэх нь зүйтэй хэдий боловч, их хэмжээний чимээ шуугиан гарвал асуудал үүсдэг.

Үндсэндээ оройн 9 цагаас хойш аль болох ахуйн дуу чимээ гаргахгүй байх хэрэгтэй. Найз нөхдөөрөө цугларан, яриа дэлгэж суух нь хөгжилтэй зүйл боловч, яриа халахаар, өөрсдийн мэдэлгүй дуу нь чангарч, ойр орчныхоо хүмүүст төвөг удах тохиолдол байдаг. Мөн, телевиз, дуу хөгжимнийхөө дууны чанга сул болон тоос сорогчийнхоо дуу чимээнд ч санаа тавих хэрэгтэй. Ялангуяа, ихэнх үед цонхoo онгойлгодог зуны улиралд, ойр орчны хүмүүст төвөг удах учраас анхаарна уу.

16. Бусад

Эргэн тойронд сургууль болон цэцэрлэгт хүрээлэн, компанийй байр зэрэг олон байгууламжуудтай ба, айлын орон сууц ч олон бий.

Бүгдээрээ аюулгүй, тав тухтай амьдрахад нь санаа тавих хэрэгтэй.

Явган хүмүүсийн замд саад болохоос болгоомжлох

Сургуульдаа ирж очих үе, үдийн хоол авахаар явах үедээ бусад явган хүмүүсийн замд саад болохоос болгоомжилно уу.

Найзуудтайгаа замаар зэрэгцэн алхвал, бусад хүмүүст саад болох болно.

Сургуулийн дүрэм болон бусад


1. Оюутны үнэмлэх

Оюутны үнэмлэх нь, тус сургуулийн оюутан гэдгийг гэрчлэх зүйл болно.

Оршин суугчийн картын нэгэн адил, сургуульдаа явах болон бусад үед алдаж гээгдүүлэхээс болгоомжлон, байнга биедээ авч явна уу. (ABK-д амьдарч буй оюутнууд мөн ижил.)

Оюутны үнэмлэх нь, шалгалтын үеэр, тодорхойлолт гаргуулахад болон бусад оюутан гэдгээ гэрчлэх тохиолдлуудад шаардагдана.

Алдаж гээгдүүлсэн, урагдаж гэмтсэн, эсвэл бичигдсэн мэдээлэлд нь өөрчлөлт гарсан тохиолдолд, Сургалтын албанад мэдэгдэж, дахин гаргуулна уу.



2. Ирц

Ирцийн хувийн тухай

Өдөр бүр, цаг бүрээр багш ирц тэмдэглэнэ.

Ирц нь тааруу оюутны сургалтанд нь ноцтой саад учраад зогсохгүй, Мэргэжлийн сургууль, Их сургуулийн бакалаврын сургалт болон магистр, докторын сургалтын элсэлтийн шалгалтын үед, мөн төгссөний дараах баталгааг олгохгүй. Цаашилбал, ирц нь тааруу байгаа тохиолдолд, торгууль ноогдуулдаг.

Их сургуульд элсэн орсны дараа, визаны хугацааг сунгахад ч, Япон хэлний сургуулийн ирцийн тодорхойлолтыг Гадаадын иргэдийн бүртгэлийн газарт хураалгах тохиолдол байдаг. Ирцийн хувь нь тааруу бол хугацааг сунгах зөвшөөрөл олгогдохгүй тохиолдол ч байдаг.

Анхааруулга!

2016 оны хуулийн өөрчлөлтөөр цагаачлалын албаны ирцийн хяналт чянгарч япон хэлний сургуулиас ирц багатай оюутнуудыг сар болгон цагаачлалын албанад мэдэгдэх шаардлагатай болсныг анхаарна уу.

Бүрэн ирцийн шагнал, Идэвхтэй оролцсоны шагнал

Бүтэн жилийн турш нэг ч удаа хичээлээ таслаагүй оюутныг “Бүрэн ирцийн шагнал”-аар, бараг таслаагүй оюутныг “Идэвхтэй оролцсоны шагнал”-аар тус тус төгсөлтийн ажиллагааны үеэр шагнана.

Ирцийн хувь шаардагдах тохиолдлууд

- (1) Их сургуулийн бакалаврын сургалт болон магистр, докторын сургалт, Мэргэжлийн сургуулийн элсэлтийн шалгалтанд бүртгүүлэх.
- (2) Нэр дэвшигдэн элсэх өргөдөл гаргах. (Ирцийн хувь нь 95% хүрэхгүй оюутнууд өргөдөл гаргах боломжгүй.)
- (3) Сургалтын тэтгэлэг авах өргөдөл гаргах. (Ирцийн хувь нь 95% хүрэхгүй оюутнууд өргөдөл гаргах боломжгүй.)
- (4) Визаны хугацаа сунгуулах болон төрлийг нь өөрчлөх.
- (5) Бусад

Жилийн ирцийн хувийг тооцох арга

(Жилийн хичээлийн цагийн тоо - Жилийн хичээл тасалсан цагийн тоо) ÷ Жилийн хичээлийн цагийн тоо × 100

Хоцорч ирэх, эрт харихыг хэрхэн тооцох

3 удаа хоцорч ирэх юм уу эрт харьсан тохиолдолд, 1 цагийн хичээл тасалсанд тооцно.

20-иос дээш минут хоцорч ирвэл, тухайн хичээлийг тасалсанд тооцно.

Хичээлдээ суухгүй тохиолдолд, өглөө (9:00-9:30-ын хооронд) Сургалтын албанад утсаар мэдэгдэх хэрэгтэй. Холбоо барьж чадаагүй тохиолдолд ч, дараа нь хичээлд суугаагүй шалтгаанаа заавал мэдэгдэнэ үү. Гагцхүү дараах (1)-д дурьдсан шалтгаантай бөгөөд, ангийнхаа багшид урьдчилан “Албан ёсны чөлөө авах хүсэлт”-ийг хураалгасан тохиолдолд, “Албан ёсны чөлөө” авсанд тооцогдох ба хичээл тасалсанд тооцогдохгүй.

“Албан ёсны чөлөө авах хүсэлт”-ийн маягтыг ангийнхаа багшаас авна уу.



(1) Албан ёсны чөлөө

- Их сургуулийн магистр, докторын сургалтын удирдагч багштай ярилцлаганд орох.
 - Их сургуулийн бакалаврын сургалт болон магистр, докторын сургалт, Мэргэжлийн сургуулийн элсэлтийн шалгалтанд бүртгүүлэх, шалгалтанд орох.
- Их дээд сургууль, ажлын шалгалтанд оролцсон үед хичээлээс чөлөө олгоно.
- Визаны хугацаа сунгуулах болон төрлийг нь өөрчлөх өргөдөл гаргах.
 - Оршин суугчийн карттай холбогдох өргөдөл гаргах.
 - Сургалтын тэтгэлэг авах ярилцлаганд орох.
 - Хамаатан саданд золгүй явдал, өвчин зэрэг үйл явдал болсон тохиолдолд (Гэрчлэх бичиг баримт хураалгах хэрэгтэй.)
 - Сургуулийн захирал тусгайлан зөвшөөрсөн арга хэмжээнд оролцох. (Тухайлбал, төгссөн сургуулийнхаа төгсөлтийн арга хэмжээнд оролцох г.м.)

(2) Хичээл тасалсанд тооцогдохгүй тохиолдол

- Тээврийн хэрэгсэл хоцорсноос шалтгаалан хичээлдээ суугаагүй, хоцорч ирсэн тохиолдол. (Тээврийн хэрэгслийн компаниас “Хоцорсон баримт” авч ирэх хэрэгтэй.)
- Хуулиар заасан халдварт өвчинөөс шалтгаалан хичээлд суухыг хориглосон тохиолдол. (Дэлгэрэнгүй мэдээллийг “8. Сургуульд явахыг хориглох халдварт өвчинүүд”-ээс харна уу.)

(3) Хичээл тасалсанд тооцогдох тохиолдол

- Өвчин туссан, төрөлт.
- “Оршин суугчийн статусаас өөр үйл ажиллагаа хийх зөвшөөрөл” авах өргөдөл гаргах.
- Их сургуулийн бакалаврын сургалт болон магистр, докторын сургалт, Мэргэжлийн сургууль дээр очиж танилцах, элсэлтийн шалгалтын бүртгэлийн маягт авах.
- Бусад

3. Тодорхойлолт гаргуулах

Төрөл бүрийн тодорхойлолтыг Сургалтын албанаас гаргана. Тогтсон маягтыг бөглөж, ангийнхаа багшаар тамга даруулан, Сургалтын албанад авч ирнэ үү. Дэлгэрэнгүй мэдээллийн талаар Сургалтын албанаас асууж тодруулна уу.

4. Сургалт дүүргэхтэй холбогдох журам

Аливаа сургалтын курсыг дүүргэхэд, сургуулийн журмаар заасан нөхцлүүдийг хангасан байх шаардлагатай.

- (1) Бүх ээлжит шалгалтыг өгсөн байх.
- (2) Төгсөлтийн шалгалтыг өгсөн байх.
- (3) Жилийн ирцийн хувь нь журамд заасан хувиас дээш байх.



ABK Япон хэлний курсын “Их сургуулийн элсэлтэнд бэлтгэх сургалтын курс (Prep. Course 2)”-ын дүүргэх талаар

ABK Япон хэлний курсын “Их сургуулийн элсэлтэнд бэлтгэх сургалтын курс (Prep. Course 2)”-т сурч буй оюутан бөгөөд, Их сургуулийн бакалаврын сургалт (Bachelor Degree) юм уу Мэргэжлийн сургууль (Professional training college)-д элсэн орохоор төлөвлөж буй оюутан нь, “Их сургуулийн элсэлтэнд бэлтгэх сургалтын курс”-ыг “Дүүргэх” шаардлагатай. “Дүүргэх”-ийн тулд, дараах нөхцлүүдийг хангасан байх шаардлагатай.

- (1) Бүх ээлжит шалгалтыг өгсөн байх.
- (2) Төгсөлтийн шалгалтыг өгсөн байх.
- (3) Жилийн ирцийн хувь нь журамд заасан хувиас дээш байх.
- (4) Тус сургалтанд шаардлагатай гэж үзэх суурь хичээлүүдэд суусан байх.
- (5) Сурлагын түвшин нь тогтсон түвшнээс дээш байх.

Тус сургалтын курсыг дүүргэх нөхцлүүдийг хангахгүй тохиолдолд, “Их сургуулийн элсэлтэнд бэлтгэх сургалтын курсыг дүүргэсэн гэрчилгээ”-г олгохгүй тул, тус сургалтанд сурч байсан ч, Их сургууль, Мэргэжлийн сургуулиас “Элсэлтийн шаардлагыг хангаагүй” гэж үзэн, элсэх боломжгүй болно. Мөн, тус сургалтын курс турч байсан ч, ирцийн байдлаас шалтгаалан тус сургалтын курсыг дүүргэх найдваргүй тохиолдолд, “Дүүргэх төлөвтэйг гэрчлэх тодорхойлолт” гаргахгүй. Энэ тохиолдолд, Их сургууль, Мэргэжлийн сургуулиас “Элсэлтийн шаардлагыг хангаагүй” гэж үзэх ба шалгалтанд ч орох боломжгүй болох тул, ирц болон сурлагадаа байнга анхааралтай хандана уу.



5. Сургалтын тэтгэлгийн систем

Жилд хэд хэдэн сургалтын тэтгэлгийн системийг оюутнууддаа танилцуулдаг. Бүртгэх үе зэрэг нөхцөл нь харилцан адилгүй байдаг ба сургалтын тэтгэлгийн танилцуулга хүлээн авмагцаа, хичээлийн танхим, зарлалын самбараар мэдэгдэх болно.

6. Сургуулийн даатгал

Анхааруулга: “Иргэний эрүүл мэндийн даатгал”-аас тусдаа, өөр даатгал.

Аливаа хэрэг, осолд өртсөн тохиолдолд, даруй сургууль руу мэдэгдэнэ үү.

Сургууль нь бүх оюутнуудаа даатгалд даатгуулдаг. Оюутнууд гэмтлийн осол, эсвэл бусдад хохирол учруулах осол (Хохирлыг нь нөхөн барагдуулах шаардлагатай осол) гаргасан тохиолдолд, тогтсон хэмжээний даатгалын мөнгө төлөгдөнө. Осолд өртсөн тохиолдолд, даруй Сургалтын албандаа мэдэгдэнэ үү.

Нөхөн олговрын агуулга	Даатгалын мөнгө, нөхөн олговрын дээд хэмжээ
Авран туслагчийн зардлын даатгалын мөнгө (Төлөгдөх дээд хэмжээ)	1,000,000 иен
Нас баралт, Ослоос үүдсэн эмгэг үр дагаварын даатгалын мөнгө (Хамгийн дээд хэмжээ)	1,000,000 иен
Хохирлыг нь нөхөн барагдуулах даатгалын мөнгө (Нэг ослын дээд хэмжээ)	50,000,000 иен

Анхааруулга:

- (1) Иргэний эрүүл мэндийн даатгал болон Нийгмийн даатгалаас тусдаа, өөр даатгал болно. Сургуулийн даатгалд хамрагдсан байсан ч, Иргэний эрүүл мэндийн даатгал, эсвэл Нийгмийн даатгалд заавал хамрагдах шаардлагатай.
- (2) Бусдад хохирол учруулах осол (Хохирлыг нь нөхөн барагдуулах шаардлагатай осол) гаргасан тохиолдолд, тохиролцоо хийлгүйгээр, цагдаагийн газар болон сургууль руу заавал мэдэгдэх хэрэгтэй.

7. Хар салхины улмаас хүчтэй шуургатай үед эсвэл газар хөдлөлт

Үүссэн тохиолдолд хичээл орох нь

7-1. Хар салхины улмаас хүчтэй шуургатай үед хичээл орох нь

Хар салхи Токиод ойртсоноор, Токиогийн 23 дүүрэг (Токиогийн 23 дүүргийн зүүн бүс юм уу баруун бүсэд албан ёсоор зарлагдсан тохиолдолд мөн ижил.)-т Цаг уурын газраас “Шуурганы сэрэмжлүүлэг” албан ёсоор зарлагдсан тохиолдолд, хичээлийг доор дурьдсаны дагуу зогсоон.

Тухайн өдрийн өглөө нь, Цаг уурын газрын цахим хуудас (<http://www.jma.go.jp/jma/index.html>) болон телевизийн мэдээгээр нягталж харна уу.


- Үдээс өмнө 7 цагийн байдлаар “Шуурганы сэрэмжлүүлэг” албан ёсоор зарлагдаж буй тохиолдол → Үдээс өмнөх хичээлийг зогсоон.
- Үдээс өмнө 10 цагийн байдлаар “Шуурганы сэрэмжлүүлэг” зарлагдсан хэвээрээ байгаа тохиолдолд → Үдээс хойших хичээлийг ч зогсоон.

[Интернетээр шалгах арга]


1. Цаг уурын газар (www.jma.go.jp) -ын цахим хуудасны “Цаг агаарын сэрэмжлүүлэг, анхааруулах мэдээ”-т дарна уу.



2. Токио хотыг дарна уу.



3. Токиогийн 23 дүүргийн “Шуурганы сэрэмжлүүлэг” багананд тэмдэг (●) тавигдсан байвал, “Шуурганы сэрэмжлүүлэг” албан ёсоор зарлагдсан гэсэн үг.



☆Токиогийн 23 дүүргэс өөр бүсэд оршин суудаг тохиолдолд, оршин сууж буй бүсэд тань “Шуурганы сэрэмжлүүлэг” албан ёсоор зарлагдсан бол, сургуульдаа явалгүй, өмнө дурьдсан журмыг дагана уу.

7-2. Газар хөдлөлт үүссэн тохиолдолд хичээл орох нь

Токиогийн 23 тойрогт газар хөдлөлтийн 5 балл болон түүнээс хүчтэй газар хөдлөлт өмнөх өдрийн оройны 5 цагаас тухайн өдрийн хичээл эхлэх хоорондох хугацаанд үүссэн тохиолдолд тухайн өдрийн үдээс өмнөх болон үдээс хойших ангийн хичээл амрана.

Тухайн өдрийн өглөө, цаг уурийн хүрээлэнгийн нүүр хуудас (<http://www.jma.go.jp/jma/index.html>) болон зурагтын мэдээгээр тодруулна уу.

Түүнчлэн зам тээврийн saat, газар хөдлөлтийн хохирлын байдлаас шалтгаалан, онцгой тохиолдолд, сургуулийн захирлын шийдвэрээр хичээл орохгүй байж болно.

* Япон дахь газар хөдлөлтийн хүчний талаар дараах хэсгээс тодруулна уу.

Япон дахь газар хөдлөлтийн хүчний үзүүлэлт

Японд 2012 оны байдлаар, 4,300 хэсэгт үзэгдсэн газар хөдлөлтийн хүч (балл) нь 0-ээс 7 хүртэлх байх бөгөөд 10 түвшинд харагдана.

Балл	Чичиргээний төлөв байдал
0	Чичиргээн нь хүнд мэдрэгдэхгүй боловч газар хөдлөлтийн хүчийг хэмжих багажинд бүртгэгдэнэ.
1	Гэртээ нам гүм байгаа хүмүүсийн цөөнх нь чичиргээнийг мэдэрнэ.
2	Гэртээ нам гүм байгаа хүмүүсийн ихэнх нь чичиргээнийг мэдэрнэ. Унтаж буй хүн сээрэх нь бий.
3	Гэртээ байгаа ихэнх хүмүүст чичиргээн мэдрэгдэнэ. Алхаж байхдаа чичиргээнийг мэдэрч болно. Унтаж буй ихэнх хүмүүс сэрнэ.
4	Ихэнх хүмүүс цочирдолд орно. Алхаж байхад чичиргээн мэдрэгдэнэ. Унтаж байгаа бараг бүх хүн сэрнэ.
5(сул)	Ихэнх хүмүүс айж сандарч, аюулыг мэдэрнэ. Тавиурт байгаа сав суулга, ном унах нь бий. Тогтвортой бус зүйлс нурж унах аюултай. Бэхлэгээгүй тавилга байршлаа өөрчлөн хөдөлнө.
5(хүчтэй)	Юмнаас барихгүй бол алхаж явахад хэцүү болно. Гэрийн хүнд тавилгууд унах магадлалтай. Бэхжүүлээгүй блок хашаа нурж унах эрсдэлтэй.
6(сул)	Зогсоход бэрхшээлтэй.
6(хүчтэй)	Зогсож чадахгүй ба мөлхөхөөс өөр үйлдэл хийж чадахгүй болно. Чичиргээний эрхэнд хөдлөж ч чадахгүй ба шидэгдэх магадлалтай.
7	Зогсож чадахгүй ба мөлхөхөөс өөр үйлдэл хийж чадахгүй болно. Чичиргээний эрхэнд хөдлөж ч чадахгүй ба шидэгдэх магадлалтай.

8. Сургуульд явахыг хориглох халдварт өвчинүүд

Доор дурьдсан халдварт өвчнийг туссан тохиолдолд, Сургуулийн эрүүл мэндийн тухай хуулийн дагуу сургуульд явж болохгүй.

Сургуулийн тогтсон маягт “Сургуульд явахыг зөвшөөрөх бичиг”-ээр эмчийн зөвшөөрлийг авсны дараа сургуульд явж болно.

“Сургуульд явахыг зөвшөөрөх бичиг”-ийн маягтыг уг материалын төгсгөлд хавсаргасан байгаа бөгөөд уг маягтыг хуулбарлан, эмчээр бичүүлж авна уу.

1. Томуу (Өвчин илэрснээс хойш 5 хоног өнгөрч, мөн халуун буурснаас хойш 2 хоног өнгөрөх хүртэл)
2. Хөхүүл ханиад (Онцлогтой ханиалгах нь намдтал, эсвэл 5 хоног бактерийн эсрэг бодисын бэлдмэлээр эмчилж дуусах хүртэл)
3. Улаан бурхан (Халуун буурснаас хойш 3 хоног өнгөрөх хүртэл)
4. Гахайн хавдар (Хавдар бууснаас хойш 5 хоног өнгөрч, мөн бүх биений эмгэг шинж тэмдэг нь сайжрах хүртэл)
5. Улаанууд (Тууралт нь арилах хүртэл)
6. Салхин цэцэг (Бүх тууралт нь хатах хүртэл)
7. Фаринго-конюнктивал чичрэг (Голлох шинж тэмдгүүд нь арилснаас хойш 2 хоног өнгөрөх хүртэл)
8. Сүрьеэ, Менингит, Нянгийн гаралтай менингит (Халдвартай даатгалыг өөрчлөх зэрэг ажлыг хийх хэрэгтэй. Мөн, оюутны үнэмлэхийг дахин гаргах тул, Сургалтын албанад мэдэгдэнэ үү. Оюутны үнэмлэхийг дахин гаргахад, хаягийг нь өөрчилж шинэчилсэн оршин суугчийн карт болон Иргэний эрүүл мэндийн даатгалын карт хэрэгтэй.
9. Бусад



9. Бусад

Оршин суугаа хаяг өөрчлөгдөх талаар

Японд ирсний дараа, нүүх зэрэг шалтгаанаар оршин суугаа хаяг тань өөрчлөгдөх тохиолдолд, “Оршин суугчийн карт ба оршин суугчдын бүртгэлийн систем”-ийн хэсэгт дурьдсаны дагуу, оршин суугчийн картны мэдээллийг өөрчлөх, Иргэний эрүүл мэндийн даатгалыг өөрчлөх зэрэг ажлыг хийх хэрэгтэй. Мөн, оюутны үнэмлэхийг дахин гаргах тул, Сургалтын албанад мэдэгдэнэ үү. Оюутны үнэмлэхийг дахин гаргахад, хаягийг нь өөрчилж шинэчилсэн оршин суугчийн карт болон Иргэний эрүүл мэндийн даатгалын карт хэрэгтэй.

Дээрхээс гадна, гар утасны дугаар, цагийн ажил хийж буй ажлын газар, Монгол дахь хаяг болон утасны дугаар зэрэг өөрчлөгдсөн бол, Сургалтын албанад мэдэгдэнэ үү.

Asia Bunka Kaikan-ы компьютерын хэсэг, ABK COLLEGE-ийн компьютерын хэсэг

ABK Япон хэлний курс, ABK COLLEGE-ийн оюутнууд, ABK-д амьдардаг оюутнууд үнэ төлбөргүй ашиглаж болно. (Даваагаас Баасан хүртэл, 12:00-17:00 цагийн хооронд ашиглах боломжтой.) Компьютерын хэсэгт идэж уух, хоорондоо ярихаас татгалзана уу.

Принтер хэрэглэвэл: Хар цагаан хэвлэл ... 1 хуудас нь 10 иен, Өнгөт хэвлэл ... 1 хуудас нь 50 иений төлбөртэй. Сканер бүх компьютерүүдэд ашиглах боломжтой.

Оюутны дугаар

Та бүхий мэдээллийг оюутны үнэмлэхэнд бичигдсэн “Оюутны дугаар”-аар хянадаг. Тодорхойлолт гаргуулах хүсэлт гаргах, сургалтын төлбөр дансаар шилжүүлэх, ирцийн хувийг лавлаж тодруулах зэрэг тохиолдуудад оюутны дугаараа ашиглана уу.

Хичээлийн танхим

- Хичээлийн үеэр гар утсаа унтраана уу. Хичээлийн үеэр утсаар ярих нь хичээл явуулахад саад болно. Хичээлд саадтай гэж үзсэн тохиолдолд, гар утсыг хурааж авах тохиолдол байдаг.
- Хичээлийн танхимаас хамгийн сүүлд гарах тохиолдолд, гэрэл, агааржуулагчийг заавал унтрааж гарна уу. Цахилгаан хэмнэхэд хувь нэмрээ оруулна уу.
- Завсралгааын үеэр, чухал нандин зүйлсээ хичээлийн танхимд орхилгүй, биедээ авч гарна уу.
- Хогийг тогтсон газарт нь хаяна уу. Ялангуяа, ширээн дотор хог бүү хийгээрэй.
- Хичээлийн танхимд тамхи татахыг хориглоно. Тамхийг үнсний савтай газарт татна уу.
- Хичээл тарсны дараа болон амралтын өдрөөр хичээлийн танхимыг ашиглах боломжгүй.



Бие засах өрөө

- Бүх бие засах өрөөнүүд ус татаж урсгадаг хийцтэй. Хэрэглэснийхээ дараа усыг нь заавал татна уу.
- Эмэгтэйчүүдийн бие засах газрын өрөө бүрт байрлуулсан хогийн саванд хэрэглэсэн ариун цэврийн цаас бүү хаяарай. Хэрэглэсэн цаасыг усаа татахдаа хамт урсгана уу.

Сургуулиас дундаас нь гарах

Зайлшгүй шалтгаанаар төгсөхөөсөө өмнө сургуулиас гарах болсон тохиолдолд, аль болох эртхэн Сургалтын албатай ярьж зөвлөнө үү.

Сургуулиас гарахад дараах процедур шаардлагатай. Үүнд:

- Сургуулиас гарах хүсэлтийн бичиг хураалгах.
- Оюутны үнэмлэхийг буцааж өгөх.
- Бичиг баримт явуулах хуудас бөглөх. (Зардал: Жич 1,500 иен шаардагдана.)
- “Байгууллагатай холбогдох мэдэгдэл” хураалгах.
- Бусад

Цахим хуудас

ABK-ийн цахим хуудас www.abk.or.jp

ABK COLLEGE-ийн цахим хуудас www.abk.ac.jp

Цахим хуудаснаас сургуультай холбогдох нэгдсэн, төрөл бүрийн мэдээллийг авах боломжтой.

Япон хэлний сургуулийн Сургалтын алба

Ойлгож мэдэхгүй зүйл, санаа зовоож буй зүйл, сэтгэл түүшээж буй зүйл байвал, ганцаараа шаналж зоволгүйгээр, Сургалтын албанд ирж уулзана уу. Та бүхнийг сэтгэл тайван байлгаж, оюутны амьдралаа үр дүнтэй өнгөрөөхөд чин сэтгэлээсээ дэмжиж, туслах болно.

- | | |
|--|--|
| • ABK Япон хэлний курсын
Сургалтын албаны ажлын цаг | Бямба, Ням болон баяр ёслолын өдрөөс бусад Даваа-Баасан
9:00-17:00
Утасны дугаар: 03-3946-2171 E-MAIL: nihongo@abk.or.jp |
| • ABK COLLEGE-ийн Сургалтын
албаны ажлын цаг | Бямба, Ням болон баяр ёслолын өдрөөс бусад Даваа-Баасан
9:00-17:00
Утасны дугаар: 03-6912-0756 E-MAIL: info@abk.ac.jp |

登校許可書

殿

クラス _____

氏名 _____

上記の者は、下記の○印の学校伝染病が軽快しかつ学校保健法の基準により、伝染予防上支障がないと認めたので登校を許可します。

記

1. インフルエンザ(発症した後5日を経過し、かつ解熱後2日を経過するまで)
2. 百日咳 (特有の咳が消える、または五日間の抗菌性物質製剤による治療終了まで)
3. 麻疹 (解熱した後3日を経過するまで)
4. 流行性耳下腺炎(腫れが出た後5日を経過し、かつ全身症状が良好になるまで)
5. 風疹 (発疹が消失するまで)
6. 水痘 (すべての発疹が痂皮化するまで)
7. 咽頭結膜熱 (主要症状が消退後2日を経過するまで)
8. 結核、髄膜炎、菌性髄膜炎
(医師によって伝染のおそれがないと認められるまで)
9. その他 ()

登校してはいけない期間 月 日 ~ 月 日

年 月 日

住 所

T E L

医師氏名

印

ほうさい ABK防災マップ ABK disaster prevention map

《地震などの災害が授業時間内だった場合》 In case of classhour

- ① 文京グリーンコートに各クラスごとに集合し、点呼 Congregate each class at Bunkyo green court and make a muster
- ② 駒籠町小学校(避難所)に避難 Go to a place of refuge (Kagomachi elementary school)
- ③ 食糧調達が必要になったら、第九中学校(避難所)に移動 If we need foods, change to another place of refuge (Daikyu junior high school)
- ④ 各避難所にいる時に、自治体から火災等による避難勧告が出た場合、六義園(避難場所)に移動 In case that Bunkyo ward advices to go out from a place of refuge because of fire or something else, we go to Rikugien (refuge area).

《地震などの災害が授業時間外だった場合》 In case of after school

上記の(1)はなしで、(2)以降へ続く。From (2) same as above

